

**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАГНАЛ**

2023.07.26

Борхойн тал

| <b>Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/</b>   |  |                  |
|---|--|------------------|
| Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй. |  |                  |
| Тайлагнах хугацаа   | 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс 2023 оны 06 дугаар сарын 30                                       |                  |
| Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар  | Э-Транс ложистикс ХК, ETR, 99117636  |                  |
| Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр  | Хөрөнгийн бирж ТӨХК  |                  |
| Бизнесийн үйл ажиллагааны салбар  | Ачаа тээвэр, гаалийн нэг цэгийн үйлчилгээ  |                  |
| Жилийн эцсийн санхүүгийн тайланда аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо   | ИХМОНГОЛ ХӨЛӨЛГ АУДИТ ХХК, 2014 оны 09 дүгээр сарын 17   |                  |
| Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг   | 46,200,000 ширхэг  |                  |
| Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр   | Тайлан бэлтгэсэн: Дотоод ажил хариуцсан ажилтан С.Ганбат<br>Хянасан: Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа |                  |
| <b>1. Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</b>   |  |                  |
| Санхүүгийн байдлын үзүүлэлт   | Эргэлтийн хөрөнгийн дүн  | 905,948,533.63   |
|   | Эргэлтийн бус хөрөнгийн дүн  | 4,601,584,094.86 |
|   | Нийт хөрөнгийн дүн   | 5,507,532,628.49 |
|   | Богино хугацаат өр төлбөрийн дүн   | 104,108,738.84   |
|   | Өр төлбөрийн нийт дүн  | 104,108,738.84   |
|   | Эзэмшигчдийн өмчийн дүн  | 5,403,423,889.65 |
|   | Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн   | 5,507,532,628.49 |
| Орлогын тайлан  | Борлуулалтын орлого (цэвэр)  | 1,478,519,035.33 |

|    |   |  |                  |
|----|---|--|------------------|
|    |   | Нийт ашиг (алдагдал)   | 1,478,519,035.33 |
|    |   | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)  | 485,905,761.83   |
|    |   | Татварын дараах ашиг (алдагдал)  | 437,030,457.33   |
|    |   | Нийт орлогын дүн   | 437,030,457.33   |
|    | Өмчийн өөрчлөлтийн тайлан   | Өмч  | 4,620,000,000.13 |
|    |   | Нэмж төлөгдсөн капитал   | 154,000,000.00   |
|    |   | Эздийн өмчийн бусад хэсэг  | 774,858,080.00   |
|    |   | Хуримтлагдсан ашиг   | (145,434,190.48) |
|    |   | Нийт дүн   | 5,403,423,889.65 |
|    | Мөнгөн гүйлгээний тайлан  | <b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>   |                  |
|    |   | Мөнгөн орлогын дүн (+)   | 1,645,139,516.89 |
|    |   | Мөнгөн зарлага (-)   | 1,102,107,310.86 |
|    |   | Цэвэр мөнгөн гүйлгээ   | 543,032,206.03   |
|    |   | <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>   |                  |
|    |   | Мөнгөн орлогын дүн (+)   | 112,664,642.81   |
|    |   | Мөнгөн зарлагын дүн (-)  | 150,123,666.50   |
|    |   | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн   | (37,459,023.69)  |
|    |   | <b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>   |                  |
|    |   | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн   | 0.00             |
|    |   | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ   | 374,829,632.89   |
|    |   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл  | 676,663,299.15   |
| 2. | <b>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</b>   |  |                  |
|    |   | Компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс тус зөвлөлийн дэргэдэх аудитын хороог Ж.Энхтулга, Х.Батхишиг, Б.Лхагвадорж нарын бүрэлдэхүүнтэйгээр баталсан. Тус хорооноос компанийн санхүүгийн тайланг жилд нэг удаа жилийн эцсээр хэлэлцэхээр шийдвэрлэсний дагуу хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцээгүй болно. |                  |
| 3. | <b>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</b> |  |                  |

Компанийн үндсэн үйл ажиллагаа болох шилжүүлэн ачилт өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад тодорхой хэмжээгээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Хил гаалийн асуудал, хорио цээрийн нөхцөл байдал хэвийн болсонтой уялдаж экспорт, импортын ачааны эргэлт сайжирч байгаагаас шалтгаалан гаалийн хяналтын бүсэд нэвтэрч гаалийн хяналт шалгалт хийгдэх тээврийн хэрэгсэл, ачаа барааны тоо нэмэгдсэн. Гаалийн хяналтын бүсэд нийт 2023 оны эхний хагас жилийн байдлаар / 01 сарын 01-нээс 06 сарын 30 дуустал / нийт 2321 тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж нэвтэрч гаалийн хяналт шалгалтанд хамрагдсан. ГХБ-д нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо өмнөх он мөн үеийнхээс 132-оор бага байгаа ба энэ нь үйл ажиллагаа явуулж байгаа бүсэд дахин шинээр гаалийн хяналтын бүс байгуулагдаж зарим төрлийн ачаа бараа тухайн бүсэд хуваарилагдсантай холбоотой гэж ойлгож болно. Үйл ажиллагааны орлого компанийн бүх үйл ажиллагаан дээр өмнөх оноос өссөн дүнтэй байгаа ба энэ байдлыг цаашид тогтвортой байна гэж үзэхэд бас дутагдалтай байгаа юм. Өнөөдрийн байдлаар гаалийн нэг цэгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 4 компани байгаа ба хилийн боомт дахь гаалийн хяналтын бүс болон чингэлэг шалгах рентген тоног төхөөрөмж дэх гаалийн хяналтын бүс ашиглалтанд ороогүй байгаа болно. Төмөр замаар ачаа бараа шилжүүлэн ачилт хийх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх компани газар нутгийн байршилаас болоод цаашид нэмэгдэхгүй гэж дүгнэж байгаа ба өнөөдрийн байдлаар УБТЗ-ийн шилжүүлэн ачих терминал МЧ-2, МЧ-3 үйл ажиллагаа явуулж байна. Дээрх гаалийн хяналтын бүсүүдээс хилийн боомт дахь ГХБ, Чингэлэг шалгах рентген тоног төхөөрөмж дэх ГХБ-д үйл ажиллагаагаа явуулж эхлэхээр ГХБ дэх ачаа бараа багасан энэ үйл ажиллагаанаас олж байсан орлого мөн тодорхой хэмжээгээр багасах нөхцөл байдал бий болно. Иймд энэхүү асуудлыг эрсдэл багатай байлгахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, бусад орлогын хэмжээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах зэрэг ажлыг хийхээр төлөвлөөд байна.

### 3.1. Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/

Нийт ашгийн хувь: 100% /өртөггүй/  
 Цэвэр ашгийн хувь: 29.5%  
 Нийт хөрөнгийн өгөөж (ROA): 8%  
 Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE): 8%  
 Эргэлтийн харьцаа: 11.49  
 Түргэн хөрвөх чадварын харьцаа: 6.63

### 3.2. Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт

| Хөрөнгийн байдлын үнэлгээ      |                    |  |
|--------------------------------|--------------------|--|
| Төрөл                          | Үзүүлэлт           | Дүгнэлт  |
|                                | 2023 оны хагас жил | 1 төгрөг тутамд ногдох хөрөнгийн ашиглалтын байдал   |
| Хөрөнгийн ачаалал              | 0,32               |  |
| Эргэлтийн хөрөнгийн хувийн жин | 16,4%              | Эргэлтийн хөрөнгийн эзлэх жин өмнөх тайлант үеээс нэмэгдэж сайжирсан, үндсэн хөрөнгийн жин өндөр хэвээр. |

|                                   |  |  |   |
|-----------------------------------|--|--|---|
|                                   | Элэгдлийн хувь   | 40.3%  | Үндсэн хөрөнгийн элэгдлийн хувь 40 хувь |
| <b>Санхүүгийн байдлын үнэлгээ</b> |  |  |   |
| <b>Төрөл</b>                      | <b>Үзүүлэлт</b>  | <b>Дүгнэлт</b>   |   |
| Ажлын капитал                     | 2023 оны хагас жил   | Ажлын капитал сайн ба эргэлтийн харьцаа 11,49 байгаа нь үйл ажиллагаанд богино хугацааны санхүү дарамт байхгүйг илэрхийлж байна.                                       |   |
| Ажлын капиталын оролцоо           | 801,839,794.79   | Эргэлтийн хөрөнгийн 88,5% хувийг байнгын капиталаар санжүүжүүлж байна.   |   |
| Эргэлтийн харьцаа                 | 88,5%  | Эргэлтийн хөрөнгөөр БХӨТ-ийг барагдуулах чадвар сайн.  |   |
| Бие даалтын коеф                  | 11.49  | Урт хугацаат өр төлбөргүй, богино хугацаат өр төлбөрийн хэмжээ бага байгаа нь компанийг өрийн дарамтгүй бие даан үйл ажиллагаа явуулах чадамж сайтайг илэрхийлж байна. |   |
| 3.3.                              | Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл |  |   |

Хилийн хорио цээрийн байдал аажимдаа буурснаар иргэд аж ахуйн нэгжийн худалдан авах ажиллагаа сэргэн импорт, экспортын ачаа бараа тус гаалийн хяналтын бүсээр дамжин гаалийн үзлэг шалгалтанд хамрагдан татвар суутгалаа төлж гарах хүртэлх хадгалалтын үйл ажиллагаа илт сэргж ирсэнь доорх хүснэгтэн дэх орлогын байдлаас харж болно. Хагас жилийн байдлаар тус компанийн үйл ажиллагаа өмнөх жилүүдийнхээс үйл ажиллагааны бүх чиглэлд өссөн дүнтэй гарсан боловч тухайн бүс нутагт тус компанийн гаалийн чиглэлээр эрхэлж байгаа үйл ажиллагаатай адил төстэй үйл ажиллагаа эрхэлж байгаа өрсөлдөгч компаниуд нэмэгдэж байгаа, хилийн боомт дахь гаалийн хяналтын бүс ажиллаж эхлэх хугацаа ойтож байгаа зэрэг компанийн үйл ажиллагаанд сэргөөр нөлөөлөх хүчин зүйлүүд тулгарч байна. Энэ байдалд тухайн компанийн газар зүйн байрлал, иргэдэд үйлчилгээ үзүүлэх таатай нөхцөл байдал, харилцагч иргэн аж ахуйн нэгжийн хамтын ажиллагаа зэрэг давуу талууд тус компанийд байгаа ба дээрх давуу байдалдаа тулгуурласан бодлого боловсруулан ажиллахаар төлөвлөж ажиллаж байна.

| д/д | Орлогын нэр                  | 2022 оны хагас жил | 2023 оны хагас жил | Зөрүү         |
|-----|------------------------------|--------------------|--------------------|---------------|
| 1   | Ачилтын орлого               | 4,090,182          | 75,950,700         | 17,5 дахин их |
| 2   | Хадгалалт болон гарах хуудас | 279,558,000        | 1,187,170,137      | 3,2 дахин их  |
| 3   | Түрээсийн орлого             | 14,545,455         | 23,325,000         | 60,3%         |
| 4   | Бусад орлого                 | 59,917,545         | 334,283,754        | 4,5 дахин их  |

|      |  |   |
|------|--|---|
| 3.4. | Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/   | Байхгүй   |
| 4.   | Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/ |   |
|      |  | Сонирхолын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.  |
| 5.   | Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл  | Төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.   |
| 6.   | Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл   | - Компанийн хувьцаа эзэмшигчдийн эзжит хурлыг 2023 оны 04 сарын 28-ны өдөр “ БидиСек ҮЦК “ ХК-ийн цахим хурлын системээр дамжуулан зохион байгуулсан. |

|    |   |
|----|---|
|    | <p>Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн:</p> <ul style="list-style-type: none"> <li>Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт</li> <li>Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан</li> <li>Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах</li> <li>Компанийн 2023 оны стратеги төлөвлөгөөг батлах</li> <li>ТУЗ-ийн 2023 оны цалин урамшууллын төсөв батлах</li> <li>ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох</li> <li>Ногдол ашгийн талаар гаргасан шийдвэрийг танилцуулах</li> </ul> <ul style="list-style-type: none"> <li>- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь улиран сонгогдсон бөгөөд гишүүдийн хурлыг 2023 оны 06 дугаар сарын 11-ний өдөр эчнээгээр зохион байгуулан төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, зөвлөлийн дэргэдэх хороодын гишүүдийг шинэчилж томилсон. Тухайн гишүүдийг томилоходо компанийн засаглалын кодексийг баримталсан болно.</li> <li>- 2022 оны жилийн санхүүгийн үйл ажиллагаа, тайлagnalд ИхМонгол хөлөг аудит ХХК-иар аудит хийлгэн аудитын дүгнэлт тайлagnalыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн.</li> <li>- Компанийн цахим хуудсыг шинэчлэн бэлэн болгосон. Компанийн засаглалын кодекст тогтоож өгсөн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам заавар, үйл ажиллагаа, санхүүгийн тайлagnaluуд зэрэг баримт бичгүүдийг хувьцаа эзэмшигчидэд шууд үзэх болон татааж авах байдаар хийж байршуулсан. Цаашид цахим хуудас болон сошиал хуудаснуудын байнгын ажиллагааг хангаж ажиллахад анхаарч ажиллаж байна.</li> <li>- Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлagnaluудыг хууль журмаар тогтоосон хугацаанд нь гарган Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэн ажиллаж байгаа ба Хөрөнгийн биржийн цахим хуудсанд тайлagnaluудыг тогтмол байршуулж байна.</li> <li>- Компанийн үйл ажиллагаанд дагаж мөрдүүлэх заавар, журмуудыг шинээр үлгэрчилсэн журам зааврыг баримтлан боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж үйл ажиллагаандaa ашиглаж байна.</li> <li>- Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний тайланг Хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж үнэлэлт дүгнэлт өгүүлж ажиллаж байна.</li> </ul> |
| 7. | <b>Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</b>  |
|    | Компанийн засаглалын кодекс шинэчлэгдсэнтэй холбоотойгоор засаглалтай холбоотой шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.  |

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр Чулуун Амарсанаа

Албан тушаал “Э-Транс ложисикс” ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг

(Тамга/тэмдэг)



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн  
этгээдийн гарын үсэг огноо

Овог, нэр Сайнномцэрэн Ганбат

Албан тушаал Дотоод ажил, хяналт хариуцсан ажилтан

Гарын үсэг



Овог, нэр

Албан тушаал “Их Монгол хөлөг аудит” ХХК аудитын компанийн  
гүйцэтгэх захирал

Гарын үсэг

(Тамга/тэмдэг)